

2024 оны 03 сарын 07-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсэг, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсэг, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэг болон Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Ногдол ашиг хуваарилах тухай” 03 тоот тогтоолын 3 дахь заалтын “2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр” гэснийг “2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөр”, 4 дэх заалтын “2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр” гэснийг “2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр” гэж тус тус өөрчилсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг олгох өдөрт оруулсан өөрчлөлтүүдийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид мэдэгдэх, хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу мэдээлэх, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

